



**Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа
БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2026 оны VIII сар)

Сөүл хот, 2026 он

ГАРЧИГ

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ VII САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....3

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ3

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил.....3

1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ.....3-4

1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ4-6

1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (хүснэгтээр)6

1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо6

1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт6

1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт.....7-8

2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ. 8

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ.....8

2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажил8

2.3. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр).....8-9

3. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД АЖЛУУД

3.1. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ.....9

3.2. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ9-10

3.3. Сургалт, сурталчилгаа, явуулын үйлчилгээ.....10-11

3.4. Нийгмийн даатгалын зөвлөгөө, мэдээлэл, бусад үйлчилгээ.....11

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ VIII САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаа нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хэрэгждэг.

Тус төв нь БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээг, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм.

2026 оны VIII сард төвийн дүрэм, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, иргэдэд хүргэсэн төрийн үйлчилгээг (хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон нийгмийн даатгалын чиглэлээр ангилж) энэхүү тайланд дурьдав.

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлант хугацаа 2026.08.01- 2026.08.31)

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2026 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **210** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд, холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, орчуулгын үйлчилгээ үзүүлэх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх зэрэг үйлчилгээ үзүүлэн, иргэдийн гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын компаниас оршин суух хугацаа дуусгавар болсны даатгалын төлбөр 31,151,090 вон, нутаг буцах зардал 3,957,260 вон, Ажил олгогчоос үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө 25,961,879 вон, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс 22,849,000 вон нийт **83,919,229** воныг Монгол Улсын **23** иргэнд (*давхардсан тоогоор*) олгуулав.

1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ

- Иргэн Т.Т (Е-9) хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байсан хугацааны нутаг буцах зардал 500,000 вон, 13 дахь сарын цалин 2,260,710 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн дансанд нь олгуулж шийдвэрлэсэн.
- Иргэн Ц.Д (Е-9) хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байсан хугацааны нутаг

буцах зардал 537,000 won, 13 дахь сарын цалин 8,669,750 woныг Самсунг даатгалаас нэхэмжлэн дансанд нь олгуулж шийдвэрлэсэн.

- Иргэн Л.Н (Е-9) 13 дахь сарын цалин, нутаг буцах зардал олгуулах өргөдлийг хүлээн авч Самсунг даатгал руу холбогдох материалын бүрдүүлбэрийг ханган шийдвэрлэхээр илгээсэн.
- Иргэн Л.Г (Е-9) 13 дахь сарын цалин, нутаг буцах зардал олгуулах өргөдлийг хүлээн авч материалын бүрдлийг ханган холбогдох ажиллагаа хийв.
- Иргэн Ж.Г (Е-9) 13 дахь сарын цалин 10,135,450 won, нутаг буцах замын зардал 500,000 won, нийт 10,635,450 woныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулж шийдвэрлэсэн.
- Иргэн Г.Ө (Е-9) 13 дахь сарын цалин 9,548,890 won, нутаг буцах замын зардал 537,000 won, нийт 10,085,890 woныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулж шийдвэрлэсэн.
- Иргэн П.Б (Е-9) нутаг буцах зардал 350,000 woныг олгуулж шийдвэрлэсэн.
- Иргэн С.А (Е-9) илүү цагийн цалинтай холбоотой өргөдлийг хүлээн авч харьяа хөдөлмөрийн хэлтэст өргөдлийг шийдвэрлэсэн.
- Иргэн А.Г (Е-9) илүү цагийн цалинтай холбоотой өргөдлийг хүлээн авч холбогдох ажиллагааг хийж гүйцэтгэн харьяа хөдөлмөрийн хэлтэст өргөдлийг шилжүүлсэн.
- Иргэн Б.Б (Е-9) 13 дахь сарын цалингийн зөрүүг тооцож ажил олгогчоос 1,552,912 woныг олгуулан өргөдлийг шийдвэрлэсэн.
- Иргэн Б.Э (Е-9) 13 дахь сарын цалингийн зөрүүг тооцож 1,886,033 woныг ажил олгогчоос гаргуулан олгосноор өргөдлийг шийдвэрлэсэн.
- Иргэн С.А (Е-9) 13 дахь сарын цалингийн зөрүүг тооцож 2,390,033 woныг ажил олгогчоос гаргуулан олгож өргөдлийг шийдвэрлэсэн.
- Иргэн А.Б (Е-9) 13 дахь сарын цалингийн зөрүүг тооцож 2,458,937 woныг ажил олгогчоос гаргуулан олгосноор өргөдлийг шийдвэрлэсэн.
- Иргэн А.Г (Е-9) 13 дахь сарын цалингийн зөрүүг тооцож 2,313,935 woныг ажил олгогчоос гаргуулан олгож өргөдлийг шийдвэрлэсэн.
- Нийт 12 гэрээт ажилчинд ажлын байр солих, олгогдоогүй цалин хөлс, ажилгүйдлийн тэтгэмж авах, нутаг буцах замын зардал, 13 дахь сарын цалин нэхэмжлэх, хөдөлмөрийн гэрээ сунгах болон бусад асуудлаар зөвлөгөө өгч орчуулгын үйлчилгээ үзүүлж ажилласан.

1.1.2. Бусад төрлийн визтэй болон хууль бусаар оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ, өргөдөл гомдлын шийдвэрлэлт

- Иргэн Н.З (визгүй) гаргасан өргөдлийг хүлээн авч 13 дахь сарын цалингийн тооцооллыг хийж, Зүүн бүсийн Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газарт хүсэлт гаргаж 14,956,000 woныг олгуулж шийдвэрлэсэн.
- Иргэн Т.Б болон Л.М (бусад төрлийн визтэй) нарын олгогдоогүй цалин хөлсний маргааны асуудлаарх материалыг хүлээн авч холбогдох шалгалтыг хийж гүйцэтгэн шүүхийн шатанд шилжүүлэн ажилласан.
- Иргэн Г.А (визгүй) олгогдоогүй цалин хөлс нэхэмжилсэн өргөдлийг хүлээн авч холбогдох харьяа Хөдөлмөрийн хэлтэст шилжүүлж ажилласан.

- Иргэн Б. (визгүй) олгогдоогүй цалин хөлс нэхэмжилсэн өргөдлийг хүлээн авч холбогдох харьяа Хөдөлмөрийн хэлтэст шилжүүлж ажилласан.
- Иргэн Б.Л (визгүй) гаргасан өргөдлийг хүлээн авч, ажилласан хугацааны 13 дахь сарын цалин болох нийт 19,449,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулж шийдвэрлэсэн.
- Иргэн Э.Г (визгүй) гаргасан өргөдлийг хүлээн авч, 13 дахь сарын цалинг ажил олгогчоос нэхэмжлэх асуудлаар БНСУ-ын Сөүл хотын Гангнам дүүргийн Хөдөлмөрийн хэлтэст өргөдөл гаргасан боловч тус газраас ажил олгогчийн мэдээлэл тогтоогдоогүй, цалингийн хуудас нэмэлтээр ирүүлээгүй гэх үндэслэлээр хөдөлмөрийн хэлтсээс өргөдлийг хааж шийдвэрлэсэн.
- Иргэн Х.М (визгүй) нутаг буцах замын зардал болох 554,260 воныг олгуулж шийдвэрлэсэн.
- Иргэн Д.Б (визгүй) нутаг буцах замын зардал болох 511,000 воныг олгуулан шийдвэрлэсэн.
- Иргэн Б.А (G-1) үйлдвэрээс авах 13 дахь сарын цалин болох 8,119,294 воныг олгуулахаар 경기고용노동청 хэлтэст хүсэлт гарган нэхэмжлэн хянагдаж байна.
- Иргэн Б.Б (визгүй) олгогдоогүй цалингийн үлдэгдэл 1,413,000 воны олгуулахаар бичиг баримтыг бүрдүүлэн 고용노동부 보령고용 노동지청 хэлтэст хүсэлт гаргасан боловч 2026 оны 08 сарын 05-ны өдөр өргөдөл гаргагч өргөдлөө хаалгах хүсэлт гаргасан тул хүсэлтийн дагуу шийдвэрлэсэн.
- Иргэн Г.Ш (G-1) гаргасан өргөдлийг хүлээн авч холбогдо ажиллагааг хийж гүйцэтгэн олгогдоогүй цалин болох 200,000 воныг олгуулж шийдвэрлэсэн.
- Иргэн Г.С (G-1) олгогдоогүй цалин хөлсний материалын бүрдүүлэлт хийж Соннамын Хөдөлмөрийн асуудал эрхлэх газар (성남고용노동지청)-т баримтын бүрдлийг ханган хүргүүлээд байна.
- Иргэн Б.Ү (визгүй) гаргасан өргөдлийг хүлээн авч, олгогдоогүй цалин хөлсний материалын бүрдүүлэлт хийж 고용노동부 부천고용노동청 귀하 (Бучёний хөдөлмөрийн хэлтэс)-д хүргүүлж ажилласан.
- Иргэн Э.Т (F-6) гаргасан өргөдлийг хүлээн авч, олгогдоогүй цалин хөлс 3,200,000 воныг олгуулж, өргөдлийг шийдвэрлэсэн.
- Иргэн Б.О (визгүй) гаргасан хүсэлтийг хүлээн авч, сайн дураар нутаг буцах тухай материалыг бүрдүүлэн БНСУ-ын Цагаачлалын албаны цахим системд урьдчилсан мэдэгдлийн анкетийг бөглөн хүсэлтийг шийдвэрлэсэн.
- Иргэн Г.Б (визгүй) гаргасан хүсэлтийг хүлээн авч, сайн дураар нутаг буцах тухай материалыг бүрдүүлэн БНСУ-ын Цагаачлалын албаны цахим системд урьдчилсан мэдэгдлийн анкетийг бөглөн хүсэлтийг шийдвэрлэсэн.
- Иргэн М.Г (визгүй) гаргасан илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлт гаргасан тул холбогдох ажиллагааг хийж гүйцэтгэн шийдвэрлэсэн.
- Нийт 10 иргэнд 13 дахь сарын цалин, олгогдоогүй цалин хөлс нэхэмжлэх, визний ангилал солих, үйлдвэрлэлийн ослын тухай болон бусад асуудлаар зөвлөгөө өгч орчуулгын үйлчилгээ үзүүлэн ажиллав.

1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (хүснэгтээр)

1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо

Тоон мэдээллийн агуулга		Гүйцэтгэлийн тоон үзүүлэлт	
		Иргэн	Олгуулсан дүн (вон)
Хөдөлмөрийн гэрээт ажилчдад	1) Нутаг буцах зардал	8	3,957,260
	2) Цалин, илүү цагийн хөлс		
	3) Самсунгийн 13 дахь сарын цалин	4	31,151,090
	4) Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө	6	11,005,879
	5) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	6) Гэнэтийн ослын даатгал		
	7) Гэнэт халагдсаны тэтгэмж		
	8) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Бусад төрлийн визээр оршин суудаг иргэдэд	9) Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	2	3,400,000
	10) 13 дахь сарын цалин	1	10,799,763
	11) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	12) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13) Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	2	19,449,000
	14) 13 дахь сарын цалин	1	14,956,000
	15) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	16) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Монгол Улсын иргэдэд олгуулсан дүн		23	83,919,229

1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт

Нийт өргөдөл	Шинээр хүлээн авсан өргөдөл	Шийдвэрлэлтийн байдал			
		Хугацаанд нь шийдвэрлэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэж буй
78	44	24	26	-	24

1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт

Үйлчилгээ	Тоо
-----------	-----

1) Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал авах материалыг бүрдүүлэн, даатгалыг олгуулах, буцахтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх	нутаг	23
2) Үйлдвэрээс авах 13 сарын цалингийн зөрүү бодолт хийх аргачлалыг танилцуулах, бодолт хийх, ажил олгогчоос нэхэмжлэн олгуулах		16
3) Гэрээт ажилчдын ажлаас гарах өргөдөл гомдлын дагуу судлан, шийдвэрлүүлэх	асуудлыг	19
4) Олгогдоогүй цалин хөлсний маргааныг шийдвэрлэж, цалин, хөлсийг олгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх		17
5) Цалин, илүү цаг, амралтын хөлсийг бодох болон тооцоолох аргачлалын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх		4
6) Үйлдвэрлэлийн ослын тухай, осолд орсон иргэнийг ослын даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмж болон нөхөн олговрыг олгуулах		
7) Гэнэтийн ослын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, даатгалд хамруулж, нөхөн олговрыг олгуулах		1
8) Үндэслэлгүй болон ажил олгогчийн буруутай үйлдлээс шалтгаалан ажлын байр сольсон, гэнэт халагдсан тохиолдолд материалыг бүрдүүлэн, гэнэт халагдсаны тэтгэмж, бусад тэтгэмжийг олгуулж, өргөдлийг шийдвэрлүүлэх		1
9) Хөдөлмөрийн гэрээ сунгах (1жил 10сар), тусгай болон тогтвортой нөхцөлөөр дахин ирэх, давтан гэрээ байгуулахтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх		2
10) Бүх төрлийн аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ. Үүнд: БНСУ-ын Засгийн газрын байгууллага: - Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам - Хөдөлмөрийн хэлтэс - Төв бирж - Эрүүл мэндийн газар - Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв - Үндэсний тэтгэврийн алба - Хөдөлмөр, халамжийн газар Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай холбоотой аман болон бичгийн орчуулга		3
11) Хөдөлмөрийн гэрээт иргэдийн хамрагдах даатгал (ЭМД, ГОД, ҮОД, НД)-ын асуудлаар нарийвчилсан мэдээлэл, зөвлөгөө өгөх		4
12) Жилийн эцсийн тайлангаар ХАОАТ-ын буцаалт хэрхэн авах тухай мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх		
13) Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар (ХЭХЯ), Шүүхийн шатанд өргөдөл, гомдол гаргах асуудлыг шийдвэрлэх, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Хөдөлмөр халамжийн корпорац, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газарт иргэний өргөдлийг дамжуулан өгч шийдвэрлүүлэх		
14) Монгол иргэдийн сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргах, оршин суух хугацааг шалгах, сунгах хүсэлт гаргах, цаг авахад туслах		1
15) Визний ангилал солиулахад (Е9-өөс Е-7-4 виз рүү) оноо цуглуулах, топик шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэхэд мэдээлэл, зөвлөгөөгөөр тусалж, дэмжих		12
16) Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх		38
17) Бусад мэдээлэл, зөвлөгөө		28
18) ХурДан төрийн цахим үйлчилгээг хүргэх		41
Утсаар		99
Цахимаар		27
Танхимаар		61
Нийт		210
Хүргэсэн үйлчилгээний тоо		

2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлан хамарсан хугацаа 2026.08.01 - 2026.08.31)

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх арга хэмжээ:

- Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй иргэдээс 25 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:
 - 40 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
 - 2 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
 - 14 иргэнд шинээр гэрчилгээ олгосон. Нийт 56 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.
- БНСУ-д бусад төрлийн визтэй оршин суугч Монгол иргэдээс 42 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:
 - 28 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
 - 6 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
 - 30 иргэнд шинээр гэрчилгээ олгосон. Нийт 64 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үйлчилсэн.

2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажил

Тайлант хугацаанд тус тасаг 256,328,132.00 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд орлогын сарын төлөвлөгөө 62.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимтгэлийн 93.365,631.90 төгрөгийн орлогыг БНСУ-ын 3 банкны сангийн харилцах данснаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн банкин дахь төвлөрүүлэх дансанд бүрэн шилжүүлж, сарын мэдээг хуульд заасан хугацаанд гаргасан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуульд тус тус заасны дагуу тайлан, мэдээллийг Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

2026 оны 08 дугаар сард нийт 72 даатгуулагчийн 3 болон түүнээс дээш сарын 49,637,820.00 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Үүнд албан журмын даатгалын 42 даатгуулагчийн 31,597,900.00 төгрөг, сайн дурын даатгалын 30 даатгуулагчийн 18,039,920.00 төгрөг байна.

2.3. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

Үйлчилгээ	Тоо	Өссөн дүнгээр

1.	Даатгалд хамруулсан	шинээр	Албан журмын даатгал	25	248
			Сайн дурын даатгал	42	326
2.	Үндэсний даатгалаас гэрчилгээ олгосон (Албан журмын даатгал)	тэтгэврийн чөлөөлөгдөх	Шинээр	14	216
			Дахин	2	21
			Хугацаа сунгасан	40	237
3.	Үндэсний даатгалаас гэрчилгээ олгосон (Сайн дурын даатгал)	тэтгэврийн чөлөөлөгдөх	Шинээр	30	173
			Дахин	6	39
			Хугацаа сунгасан	28	230
4.	Шимтгэлийн төвлөрүүлэлт	орлого	Албан журмын даатгал	89,255,600	796,840,400.00 42%
			Сайн дурын даатгал	167,072.532,00 103%	1.392,565,560,01 91%
			Нийт	256,328,132.00 53%	2,189,405,960.01 62,60%
5.	Гурав болон түүнээс дээш сарын шимтгэлийн авлага барагдуулалт		Албан журмын даатгал	31,597,900,00	232,923,328.00
			Сайн дур	18,039,920.00	175,123,331.00
6.	БНСУ-ын тэтгэврийн буцаан олголт	Үндэсний даатгалын	Нэхэмжилсэн	42,257,940,00	112,237,920,00
			Олгосон	0	131,253,410
			Буцаан олголт авсан хүний тоо	0	28
7.	Иргэдэд өгсөн зөвлөгөө, мэдээлэл		Утсаар	400	2724
			Цахимаар	14	203
			Танхимаар	37	497

3. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БУСАД АЖЛУУД

3.1. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ

- Тайлант хугацаанд 38 иргэнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тулгамдсан асуудлаар нь ангилж үзвэл сэтгэл гутралын асуудалтай 10, сэтгэл түгшилттэй 9, гэр бүлийн асуудалтай 6, нойрны өөрчлөлт 2, айдас 4, архины хэтрүүлэн хэрэглээ 3, бусад шалтгаантай 10 иргэн үйлчилгээнд хамрагдав.

3.2. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ

- 2026 оны 08 дугаар сарын 07-ны БНСУ-ын Хангёл Гёньёнь Солюшн хөдөлмөр зуучлалын байгууллагын удирдлагатай уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтаар Монгол Улсын иргэдийг БНСУ-ын томоохон компаниуд болон богино хугацааны, улирлын шинжтэй ажилд зуучлах чиглэлээр санал солилцсон.
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ирүүлсэн “БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах иргэнтэй байгуулах хариуцлагын гэрээ”- ний төсөлд холбогдох нэмэлт, өөрчлөлтийн саналыг төслийг гэрээний зүйл, заалт

тус бүрт хууль эрх зүйн дүгнэлт хийж, гэрээний төслийн саналыг боловсруулж, танилцуулсан.

- Төвийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар Ёс зүйн дэд хороонд 2 гомдол, мэдээлэл ирсний дагуу ажиллаж, дүгнэлт гаргасан. Дүгнэлтийг хуульд заасны дагуу гомдол гаргагч, гомдолд холбогдогч болон томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын цахим системд бүртгүүлэв.
- 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдөр БНСУ-ын Ичон хотод байрлах Хөдөө аж ахуй, газар тариалангийн сургалтын төвөөр зочлон, удирдлагатай уулзалт зохион байгуулж, тус салбарт хөдөлмөрийн гэрээгээр ирэх Монгол Улсын иргэдэд цаашид тогтмол сургалт зохион байгуулахаар боллоо.
- Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцооны хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй Монгол Улсын иргэдийн 2026 оны 8 сарыг хүртэлх хугацаанд ирсэн нийт гэрээт ажилтнуудын судалгааг сараар нэгтгэн боловсруулсан.
- Өргөдөл гомдлын бүрдлийг хангуулж, бүртгэлийн цахим сан (google sheet)-д хариуцан, хөтлөлт, шийдвэрлэлтийн хяналт тавих ажлын хүрээнд өргөдөл, гомдол, зөвлөгөө мэдээллийн нэгдсэн мэдээг сангийн өгөгдлийн дагуу мэргэжилтэн тус бүрийн иргэдэд үзүүлсэн үйлчилгээний үзүүлэлтэд тулгуурлан үйлчилгээний төрөл, олгосон мөнгөн дүнгийн хэмжээгээр тус тус ангилан нэгтгэв.

3.3. Сургалт, сурталчилгаа, явуулын үйлчилгээ

- БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 21 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 2026 оны 08 дугаар сарын 10-ны өдөр цахимаар, ирсний дараах сургалтыг 08 дугаар сарын 12-ны өдөр үйлчилгээний салбарт ажиллахаар ирсэн 2 иргэнийг хамруулан Ичоны сургалтын төвд танхимаар тус тус зохион байгуулж дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв.Үүнд:
 - ХНХҮТ-ийн үйл ажиллагааны танилцуулга;
 - Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар;
 - Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай;
 - Солонгос улсын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар;
 - Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл;
 - Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл;
 - Ур чадвартай ажиллах хүчний E-7-4 визний талаар;
 - Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь;
 - Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал зэрэг болно.
- “МИАТ Төрийн өмчит хувьцаат компанийн оффисын ажилтнуудад бүлгийн сэтгэлзүйн зөвлөгөө, сургалт зохион байгуулж ажиллалаа. Уг зөвлөгөөний хүрээнд ажлын байрны стрессээс урьдчилан сэргийлэх, стрессийг зөв зохицуулах, сэтгэл түгшилтийг таньж мэдэн бууруулах, мөн хэцүү

үйлчлүүлэгчтэй харилцах үед үүсэх сэтгэлзүйн ачааллыг зөв удирдах зэрэг сэдвээр мэдээлэл, зөвлөмж өгч ажиллав.

- Төвийн youtube сувагт “Хэт халуунаас өөрийгөө хамгаалаарай!”, “Олгогдоогүй цалин хөлсний маргаан шийдвэрлүүлэх бол манай төвд хандаарай”, “сайн дурын даатгалд хамрагдаарай” зэрэг 3 видео контентыг нийтэлж, иргэдэд мэдээлэл хүргэж ажиллав.
- Тайлант хугацаанд мэдээ, мэдээллийг төвийн сошиал хуудаст 38, төвийн вэбсайт, төрийн байгууллагуудын нэгдсэн мэдээллийн gov.mn вэбсайтуудад 38 мэдээ, мэдээлэл нийтэлж байршуулсан.
- “Жэжү Монгол наадам 2026” явуулын үйлчилгээгээр байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, холбогдох зөвлөгөө, мэдээлэл өгч 250 иргэнд нийгмийн даатгал, хөдөлмөрийн харилцаатай холбоотой тараах материал тараав.
- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 вебинарт сургалтад нийт албан хаагчид цахимаар тухай бүр хамрагдсан.

3.4. Нийгмийн даатгалын зөвлөгөө, мэдээлэл, бусад үйлчилгээ

- БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдийг зөвлөгөө мэдээллээр дэмжих, өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ:
 - Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг танилцуулах, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг утсаар 400, цахимаар 14, танхимаар 37 нийт 451 иргэн, даатгуулагчид үзүүлсэн.
 - 2026 оны 08 дугаар сарын 12-ний өдөр БНСУ-ын Инчеон хот дахь сургалтын төвд E-9 визээр БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр хөдөө аж ахуйн салбарт ажиллахаар ирж буй 2 иргэнд Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдол, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас хэрхэн чөлөөлөгдөх талаар сургалт зохион байгуулж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.
 - 2026 оны 08 дугаар сарын 22-ний өдөр Гүми хотын Жэйл цуглааны Сандун төвийн байранд БНСУ-ын Бусан хотод суугаа Консулын газар, Төрийн банк болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран явуулын үйлчилгээ үзүүлсэн. Уг арга хэмжээний үеэр 31 иргэнд нийгмийн даатгалын тухай мэдээлэл зөвлөгөө биечлэн өгч, 11 иргэнээс нийгмийн даатгалын талаар товч судалгаа авч, 1 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулан ажилласан.
 - БНСУ-д оршин сууж байгаа Монгол Улсын иргэдээс нийгмийн даатгалын талаарх ойлголт, даатгалд хамрагддаг эсэх талаарх судалгааг 38 иргэнээс авсан.

- - - oOo - - -